


ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2026 ОНЫ НӨХӨН СОНГУУЛЬД
ОРОЛЦСОН НАМ, ЭВСЭЛ БОЛОН БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧИЙН СОНГУУЛИЙН
ЗАРДЛЫН ТАЙЛАН”-Д ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ӨМА-2026/82/-ШТА-НА



Аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Ю.Энхтуяа
Цахим хаяг: Enkhtuyayu@audit.gov.mn
Аудитын менежер: Ц.Өсөхбаяр
Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn
Ахлах аудитор: С.Одончимэг
Цахим хаяг: Odonchimegs@audit.gov.mn

Даланзадгад сум
2026 он



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ

2026 оны 09 сарын 09 өдөр

Дугаар А/29

Даланзадгад сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18.9 дэх заалт, 2025 оны А/175 дугаар "Эрх шилжүүлэх тухай" тушаалын гуравдугаар хавсралтын 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцсон нам эвсэл болон бие даан нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж олон нийтэд мэдээлэх" нийцлийн аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.
2. Нэр дэвшигчийн зардлын тайлан, мөнгөн хандивын талаарх мэдээллийг олон нийтэд хүргэхийг ахлах аудитор (С.Одончимэг)-т үүрэг болгосугай.
3. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон архивд хүлээлгэн өгөхийг ахлах аудитор (С.Одончимэг)-т хариуцуулсугай.
4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Ц.Өсөхбаяр)-т даалгасугай.



Ю.ЭНХТУЯА

1025010048

1. Аудитын нэр:

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланд хийх нийцлийн аудит.

2. Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1¹ дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2026 оны А/32 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2026 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөө”-г тус тус үндэслэн Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар нь нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хянаж баталгаажууллаа.

3. Аудитын зорилго:

Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвслээс болон бие даан нэр дэвшигчийн төвлөрүүлсэн орлого, иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандив, сонгуулийн зардлыг хянаж дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ.

4. Аудитын хамрах хүрээ:

Ханхонгор сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчийн сонгуулийн зардалд хийсэн аудитын дүгнэлт, аудитын дэлгэрэнгүй тайлан, сонгуулийн зардлын тайлангийн маягтууд, харилцагч банкны дансны хуулга бусад шаардлагатай баримтуудыг хамрууллаа.

5. Арга зүй:

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторов 2024 оны А/44 дугаар тушаалаар баталсан “Монгол Улсын Их Хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам”-ыг үндэслэн нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө, нам, эвслээс оруулсан хөрөнгө, иргэн, хуулийн этгээдээс авсан хандив түүний зарцуулалтын тайланг шалгаж аудит хийсэн хуулийн этгээд, нам, эвсэл, зарим нэр дэвшигчдээс лавлагаа, тодруулга авч бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж тайланг бэлтгэв.

¹ “Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ”

6. Үндсэн мэдээлэл:

Ханхонгор сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд 2 намаас 2 нэр дэвшигч оролцсон байна. Үүнд:

Хүснэгт № 1 Нэр дэвшигчдийн мэдээлэл

д/д	НАМ, ЭВСЛИЙН НЭР	НАМ	ЭВСЭЛ	НЭР ДЭВШИГЧИД
1	Монгол Ардын нам	1		1
2	Ардчилсан нам	1		1
	ДҮН	2		2

Эх сурвалж: Ханхонгор сумын сонгуулийн хороо

Ханхонгор сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд Ардчилсан намаас нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дансанд орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

Монгол ардын намаас нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дансанд 3,371.0 мянган төгрөгийн орлого төвлөрч сонгуулийн үйл ажиллагааны зардалд 924.8 мянга, бусад зардалд 72.1 мянган төгрөг зарцуулж 2,050.0 мянган төгрөгийг буцааж, 324.1 мянган төгрөгийг улсын орлогод төвлөрүүлж харилцах дансанд 0 төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Монгол ардын намаас нэр дэвшигчид мөнгөн бус хандив өгсөн хуулийн этгээд, иргэн байхгүй ба 6 иргэн 2,300.0 мянган төгрөгийн мөнгөн хандив өгсөн байна.

7. Сонгуулийн зардлын дансны орлого, зардал:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дүгээр зүйлийн 51.3¹-д заасны дагуу 2 нэр дэвшигч нь дансны дугаар, банкны нэрийг бүртгүүлсэн байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3²-т заасны дагуу сонгуулийн зардлын тайлангаа 2 нэр дэвшигч хугацаандаа ирүүлсэн байна.

Ханхонгор сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцсон 2 намын 2 нэр дэвшигч нь сонгуулийн зардлын тайлангаа аудитын хуулийн этгээдээр баталгаажуулж дүгнэлт авсан байна.

Монгол ардын намаас нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайлангаарх нийт орлого 1,071.0 мянган төгрөг байна. Үүнд:

¹ “Нам, эвсэл болон нэр дэвшигч нь сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй”

² “Нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ”

Хүснэгт №2 Нэр дэвшигчийн орлогын мэдээлэл

/мянган төгрөгөөр/

ОРЛОГЫН ТӨРӨЛ	ОРЛОГО				НИЙТ	
	Тоо	Мөнгөн	Тоо	Мөнгөн бус	Тоо	Дүн
Нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө	3	1,071.0	0	0	3	1,071.0
Иргэний хандив	0	0	0	0	0	0
ДҮН	3	1,071.0	0	0	3	1,071.0

Эх сурвалж: Аудитын судалгаа

Монгол ардын намын нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланд нийт 996.9 мянган төгрөгийн зардал тайлагнаснаас сонгуулийн зардалд 924.8 мянга, бусад зардалд 72.1 мянган төгрөг зарцуулсан байна. Үүнд:

Хүснэгт №2 Нэр дэвшигчдийн зардлын мэдээлэл

/мянган төгрөгөөр/

ЗАРДЛЫН АНГИЛАЛ			МӨНГӨН ДҮН
НИЙТ ЗАРДЛЫН ДҮН			996.9
2.1	Сонгуулийн зардлын дүн		924.8
2.1.1	Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах		924.8
2.1.2	Нийтийн эзэмшлийн гудамж талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэц байрлуулах		0
2.1.3	намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал		0
2.1.4	сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал		0
2.1.5	сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал		0
2.1.6	сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах зардал		0
2.1.7	цахим орчин ашиглах зардал		0
2.1.8	өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд материал нийтлүүлэх зардал		0
2.2	Бусад зардлын дүн		72.1

Эх сурвалж: Аудитын судалгаа

Зарцуулагдаагүй үлдэгдэл 74.1 мянган төгрөгийг улсын төсвийн орлогод шилжүүлсэн байна.

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторын 2024 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн А/23 дугаар тушаалаар “Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тойрогт нэр дэвшигчдийн зарцуулах зардлын дээд хэмжээ”-г тухайн тойрогт 19.3 сая төгрөг байхаар тогтоосон бөгөөд нэр дэвшигч нар зардлын дээд хэмжээг хэтрүүлээгүй байна.

Нэр дэвшигчдэд сонгуулийн зардалтай холбоотой өр төлбөр үүсээгүй байна.

8. Хуулиар зөвшөөрөгдөөгүй хандив:

Монгол ардын намын нэр дэвшигч нь хандив өгсөн иргэний нэр, бүртгэлийн дугаар болон хандивын эх үүсвэрийн талаарх мэдээлэл дутуу, буцах хаяг тодорхойгүй шалтгаанаар 2,050.0 мянган төгрөгийн хандивыг буцааж, 250.0 мянган төгрөгийг улсын орлого болгон шилжүүлсэн байна.

9. Аудитын дүгнэлт:

- ✓ Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дүгээр зүйлийн 51.3¹-д заасны дагуу нэр дэвшигчид нь дансны дугаар, банкны нэрийг бүртгүүлсэн байна.
- ✓ Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3²-д заасны дагуу нэр дэвшигчид нь сонгуулийн зардлын тайлангаа хуулийн хугацаанд ирүүлсэн байна.
- ✓ Монгол ардын намаас нэр дэвшигч нь сонгуулийн зардлын ангиллын дагуу 924.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.
- ✓ Ардчилсан намаас нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дансанд орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.
- ✓ Ханхонгор сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцсон нам болон нэр дэвшигчийн сонгуулийн зардалд иргэдээс нэг сая ба түүнээс дээш, хуулийн этгээдээс хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгөөгүй байна.

¹ “Нам, эвсэл болон нэр дэвшигч нь сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй”

² “Нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ”

Хавсралт 1

Ханхонгор сумын ИТХ-ын 2026 оны нөхөн сонгуульд оролцсон нэр дэвшигчдийн сонгуулийн орлогын мэдээлэл
/төгрөгөөр/

№	Тойрог	Тойргийн дугаар	Нэр дэвшүүлсэн нам, эвслийн нэр	Нэр дэвшигчийн		Нийт орлого	Үүнээс:				
				Овог	Нэр		Өөрийн хөрөнгө	Хандив /орлого			
								Иргэн	Мөнгөн дүн	Хуулийн этгээд	Мөнгөн дүн
1	Ханхонгор сум	12-4	Монгол Ардын Нам	Төрмөнх	Наранжаргал	1,071,050	1,071,050	-	-	-	-
2	Ханхонгор сум	12-4	Ардчилсан Нам	Аюуш	Сарантуяа	-	-	-	-	-	-
НИЙТ						1,071,050	1,071,050	-	-	-	-

Хавсралт 2

Ханхонгор сумын ИТХ-ын 2026 оны нөхөн сонгуульд оролцсон нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын мэдээлэл

/təʔrəʔəp/

№	Тойрог	Тойргийн дугаар	Нэр дэвшүүлсэн нам, эвслийн нэр	Нэр дэвшигчийн		Нийт зардал	Үүнээс:								
				Овог	Нэр		Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах	Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар,	Намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал	Сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал	Сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал	Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах	Цахим орчин ашиглах зардал	Өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд материал нийтлүүлэх зардал	Бусад зардлын дүн
1	Ханхонгор сум	12-4	Монгол Ардын Нам	Төрмөнх	Наранжаргал	996,963	924,863	-	-	-	-	-	-	-	72,100
2	Ханхонгор сум	12-4	Ардчилсан нам	Аюуш	Сарантуяа	-	-	-	-	-	-	-	-	-	-
Нийт						996,963	924,863								72,100

Хавсралт 3**Нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээд***/төгрөгөөр/*

№	Сумын нэр	Тойргийн дугаар	Нэр дэвшүүлсэн нам, эвслийн нэр	Нэр дэвшигчийн		Хандив өгсөн			
				Овог	Нэр	Иргэний нэр	Мөнгөн дүн	Хуулийн этгээдийн нэр	Мөнгөн дүн
1	Ханхонгор сум	12-4	Монгол Ардын Нам	Төрмөнх	Наранжаргал	-	-	-	-
2	Ханхонгор сум	12-4	Ардчилсан нам	Аюуш	Сарантуяа	-	-	-	-